

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААРХИ ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН ТУХАЙ

/ЗӨВЛӨМЖ/

2003 оны 09 дүгээр
сарын 10 ны өдөр

Улаанбаатар
хот

Улсын Дээд шүүхийн Судалгааны төвөөс Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны хуралдаанаар 2003 оны эхний хагас жилд хянаж шийдвэрлэсэн 280 тогтоолыг уншиж, шүүхийн практик судаллаа. Эдгээр 280 тогтоолын 35 нь цагаатгалын хэрэг байна.

Судалгааны зорилго нь шинэ Эрүүгийн хууль, Эрүүгийн Байцаан шийтгэх хуулиудыг шүүхийн практикт хэрэглэж байгаа байдал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарч буй нийтлэг алдаа, зөрчил дутагдлуудыг гаргаж ирэхэд чиглэгдсэн болно. Хагас жилийн хугацаанд нийт 436 шүүгдэгчид холбогдох 245 эрүүгийн хэрэг хянагдсан ба эдгээрийг аймгуудаар нь үзүүлбэл: Архангай 6, Баянхонгор 4, Баян-Өлгий 10, Булган 11, Говь-Алтай 7, Говьсүмбэр 5, Дархан-Уул 11, Дорнод 9, Дундговь 3, Дорноговь 5, Завхан 5, Орхон 12, Өмнөговь 9, Сүхбаатар 9, Сэлэнгэ 6, Төв 8, Увс 5, Хэнтий 1, Ховд 3, Хөвсгөл 11, Нийслэл, дүүргийн шүүхүүдийн 104 эрүүгийн хэргийг хянаж, 35 эрүүгийн хэргийг цагаатгасан байна. Харин Өвөрхангай аймгийн шүүхээс нэг ч хэрэг хянагдаагүй байна.

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимаас 245 эрүүгийн хэргийг хянаад 126 хэргийн тогтоолыг хэвээр үлдээсэн нь нийт хянагдсан хэргийн 51,4 хувийг, 60 эрүүгийн хэргийн тогтоолыг хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 24,5 хувь, 63 хэргийн тогтоолд өөрчлөлт оруулсан нийт хянагдсан хэргийн 25,7 хувийг эзэлж байна.

Судалгаанаас үзэхэд анхан болон давж заалдах шатны шүүхийн тогтоол, магадлал дорхи шалтгаанаар өөрчлөгдөж, хүчингүй болж байна.

Нэг. Эрүүгийн хуулийг хэрэглэх талаар.

Сүм болон сүм дүнд дүүргийн шүүхээс гаргаж буй нийтлэг алдаанууд:

1. Хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж, яллах дүгнэлттэй ирүүлсэн хэргийг хохирогч, шүүгдэгчтэй эвлэрсэн гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ. Жишээ нь: Шүүгдэгч О.Баярбат, Ц.Цэдэвсүрэн нар бүлэглэн иргэн Б-г зодож биед нь хөнгөн гэмтэл учруулсан хэрэгт прокуророос Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйлийн 99.2-т зааснаар яллуулахаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх 2002 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 131 дүгээр шийтгэх тогтоолоор Эрүүгийн Байцаан шийтгэх хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан “Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийн хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгоно” гэсэн үндэслэлээр шүүгдэгч О.Баярбат, Ц.Цэдэвсүрэн нартай хохирогч “Б”-г эвлэрсэн гэж дүгнэж, хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Мөн ийм төрлийн алдааг Баянхонгор аймгийн давж заалдах шатны шүүх гаргасан байна. Тухайлбал: Баянхонгор аймаг дахь сум дундын шүүх 2002 оны 233 дугаар шийтгэх тогтоолоор Б.Батчулуун, Г.Батдолгор, Г.Янжмаа, О.Өлзийбат, П.Сумъяа нарын зарим үйлдэл болох бусдыг бүлэглэн зодож хөнгөн гэмтэл учруулсан эрүүгийн хэргийн талаар үндэслэл бүхий дүгнэлт хийж, шүүгдэгч нарын гэм бурууг зөв тогтоож, хуульд заасан ял шийтгэлийг оногдуулсан байхад аймгийн давж заалдах шатны шүүх “эвлэрч байгаа” гэдэг үндэслэлээр Эрүүгийн хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсгийг хэрэглэж, Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйлийн 99.2-т заасан хүндэвтэр хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн зарим зүйл хэсэгт нэмэгдэл ял заавал хэрэглэх эсхүл хэрэглэх буюу хэрэглэхгүйгээр ял шийтгэл оногдуулж байхаар заасан байхад нэмэгдэл ялын асуудлыг шийдвэрлэхгүйгээр орхисон байна. Тухайлбал: Төв аймаг дахь сум дундын 2-р шүүх 2003 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 29 дүгээр шийтгэх тогтоолоор шүүгдэгч Ч.Чинзориг, Б.Амгаланбаатар нарт Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.3 дахь хэсэгт зааснаар ял шийтгэл оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 215 дугаар

зүйлийн 215.3-д заасан “тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг заавал хасах”-аар заасан заалтыг хэрэглээгүй байна.

3. Хэргийн зүйлчлэлийг хууль зүйн үндэслэлгүйгээр өөрчлөх явдал нилээд түгээмэл байна. Жишээ нь: Ч.Батбаяр гэгч нь өөрийн насанд хүрээгүй охиныг удаа дараа хүчиндсэн гэмт хэрэг үйлдэж, энэ хэрэгт нь Прокуророос Эрүүгийн хуулийн 112 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг Говь-Алтай аймгийн сум дундын шүүх 2002 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 150 дугаар шийтгэх тогтоолоор 2002 оны Эрүүгийн хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг болгон өөрчилж, Ч.Батбаярыг торгох ялаар шийтгэсэн байх бөгөөд шүүх тогтоолдоо Ч.Батбаярын үйлдлийг 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдсэн гэж үзэж зүйлчлэлийг өөрчилсөн үндэслэлээ тодорхой заагаагүй, хэрэв охин нь 16 насанд хүрсэн бол эцэгтэйгээ хурьцал үйлдэж болох мэт ойлгомжгүй, хэргийн бодит байдалтай нийцээгүй дүгнэлт хийсэн байна.

4. 1987 оны Эрүүгийн хуулийн бусдын эд хөрөнгийг бага хэмжээтэйгээр ашиглан шамшигдуулах 131 дүгээр зүйл, мал хулгайлах 123¹ дүгээр зүйлийн хэргүүд нь шинэ Эрүүгийн хуулиар хулгайн гэмт хэрэгтэй нэгтгэгдэж биеэ даасан зүйл хэсэг байхгүй болсон байхад эдгээр хэргийн үйлдлүүдийг хулгайн гэмт хэргээс нь тусад нь зүйлчилж ял оногдуулах, хорих ял эдлүүлэх дэглэмийг шийдвэрлэхдээ шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулж байгаа зөрчил цөөн биш удаа гарсан байна. Жишээ нь: Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүх 2002 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 148 дугаар шийтгэх тогтоолоор С.Баатарсүх гэгчид Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийн 4, 123¹ дүгээр зүйлийн 1, 127 дугаар зүйлийн 2, 131 дүгээр зүйлийн 2 дахь хэсгээр 8 жилийн хорих ял оногдуулахдаа бусдын эд хөрөнгийг бага хэмжээтэйгээр ашиглан шамшигдуулсан, мал хулгайлсан үйлдлүүдийг хулгайн гэмт хэргээс нь тусад нь зүйлчилж ял оногдуулжээ.

5. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ялын хэмжээг хугацаа тоолох журмын хувьд зөв хэрэглэж чадахгүй байна.

Тухайлбал: Дархан-Уул аймгийн сум дундын шүүх 2002 оны 10 дугаар сарын 25-ны 362 дугаар шийтгэх тогтоолоор Түвшинтөгс, Дарханбаатар, Ганзориг нарын иргэн О-г бүлэглэн зодож, амь насыг нь хохироосон гэмт хэрэг үйлдсэн хэрэгт 15 жилийн хорих ял оногдуулж, Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.2-д заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд “15-с дээш” хорих ял оногдуулах заалтыг зөрчсөн, Завхан аймгийн сум дундын шүүх 2003 оны 11 дүгээр шийтгэх тогтоолоор Д.Баатар гэгчид Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсэгт зааснаар ял оногдуулахдаа хуульд “таваас дээш 8 жил хүртэл” гэж заасан байхад 5 жилийн хорих ял оногдуулсан, мөн Өмнөговь аймгийн сум дундын шүүх 2002 оны 222 дугаар тогтоолоор Н.Отгонбат, Б.Одончимэд, Б.Отгончулуун нарт ял шийтгэл оногдуулахдаа “3, 4, 5 сар хүртэл хугацаагаар баривчлах” гэж баривчлах ялын хугацааг тодорхой биш зааж хууль буруу хэрэглэжээ.

6. Ялтай байгаа буюу хянан харгалзах хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдсэн этгээдийн ялыг дахин тэнсэж зөрчил гаргасан байна. Жишээ нь: Баянзүрх дүүргийн шүүх хянан харгалзах хугацаанд дахин хулгайн гэмт хэрэг үйлдсэн В.Баясгалан гэгчид оногдуулсан ялаа дахин тэнсэж, Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь заалтыг зөрчжээ.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн тогтоолыг үндэслэлгүйгээр өөрчлөх явдал цөөнгүй байна.

1. Булган аймгийн сум дундын шүүх 2003 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 53 дугаар шийтгэх тогтоолоор С.Гантөр, Л.Мөнхтөр нарт бусдын морийг бүлэглэн хулгайлсан үйлдэлд нь тохирсон ял оноосон байхад давж заалдах шатны шүүх “Гантөр, Мөнхтөр нар нь бусдын адуунаас морь эцсэн гэсэн шалтгаанаар 2 морь авч, өөрсдийн морийг уг адуунд оронд нь тавиад унаж явсан болох нь хэрэгт авагдсан нотлох баримтаар тогтоогдсон” гэж нотлох баримтаар тогтоогдоогүй, хууль зүйн ямар ч үндэслэлгүй дүгнэлт хийж тэдэнд холбогдох хэргийг зөвхөн Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-ийн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэсэн заалтыг баримтлан хэргийг хэрэгсэхгүй болгож байжээ.

2. Говьсүмбэр аймгийн сум дундын шүүх 2003 оны 04 дүгээр шийтгэх тогтоолоор удаа дараа хүнд гэмт хэрэг үйлдэж, хорих ангид ял эдэлж байхдаа дахин хүнд гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгч С.Зоригт ял шийтгэл оногдуулахдаа Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар ... урьд хүнд гэмт хэрэг үйлдэж 2 удаа шийтгүүлж уг ялаа эдэлж байхдаа дахин хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн этгээдийг шүүх онц аюултай гэмт хэрэгтнээр тооцно гэсэн хуулийн заалтыг зөв хэрэглэсэн байхад аймгийн давж заалдах шүүх шүүгдэгч С.Зоригтоог засрал хүмүүжил олсон гэж үзэж сум дундын шүүхийн тогтоолыг үндэслэлгүйгээр өөрчилж Эрүүгийн хуулийг буруу хэрэглэжээ.

3. 2002 оны 12 дугаар сард бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орж 9600 төгрөгийг согтуугаар, бүлэглэн хулгайлсан А.Серикжан, Е.Хуаныш нарт Баян-Өлгий аймгийн сум дундын шүүх 2003 оны 19 дүгээр шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар тус бүрийг 3 сар 15 хоног баривчлах ялаар шийтгэсэн нь үндэслэлтэй байхад аймгийн давж заалдах шатны шүүх зөвхөн гэмт хэргийн хохирлын хэмжээнд дүгнэлт хийж, бүлэглэсэн, орон байранд хууль бусаар нэвтэрсэн нөхцөл байдлыг харгалзан үзэхгүйгээр Эрүүгийн хуулийн 16-р зүйлийн 16.2 дахь хэсэгт заасныг баримтлан шүүгдэгч А.Серикжан, Е.Хуаныш нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож хууль буруу хэрэглэсэн байна.

4. Давж заалдах шатны шүүхээс хэргийг давж заалдсан гомдлоор хянан хэлэлцэхдээ анхан шатны шүүхийн хууль буруу хэрэглэсэн болон бусад алдаа зөрчлийг олж, засахгүйгээр хянах явдал их байна. Тухайлбал: Орхон аймгийн сум дундын шүүх 2002 оны 267 дугаар тогтоолоор тээврийн хэрэгсэл жолоодож явахдаа хоёр хүнийг мөргөж, биед нь хүндэвтэр гэмтэл учруулсан Батжил гэгчид Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.2 дахь хэсэгт зааснаар 3 сарын хугацаагаар баривчлах, Эрүүгийн хуулийн /1987 оны/ 109 дүгээр зүйлийн 1-д зааснаар 30000 төгрөгөөр торгох ял шийтгээд, Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасны дагуу нэгтгэж, түүний жинхэнэ эдлэх ялыг тогтоогоогүй байхад аймгийн давж заалдах шатны шүүх уг тогтоолыг хэвээр үлдээжээ.

Хоёр. Эрүүгийн Байцаан шийтгэх хуулийг хэрэглэх талаар.

1. Шүүх хуралдаанд хохирогч оролцох боломжийг хангахгүй байх, ЭБШХ-ийн хуулийн 42 дугаар зүйлийн 3, 4 дэх заалтыг зөрчих, улсын яллагч шүүх хуралдаан дээр шүүгдэгчийг яллахаас татгалзсан тохиолдолд дүгнэлтийг бичгээр гаргуулан авах ЭБШХ-ийн 239 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг зөрчих, хүнд, онц хүнд гэмт хэргийг шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг дутуу оролцуулж ЭБШХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийг зөрчих, шүүх хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зурахгүй, тамга дарахгүй орхих, анхан шатны шүүх хуралдаанд оролцсон нарийн бичгийн даргыг давж заалдах шатны шүүх хуралдаанд дахин нарийн бичгийн даргаар оролцуулж ЭБШХ-ийн 50, 55 дугаар зүйлийн заалтыг ноцтой зөрчсөн зэрэг нь шүүхийн тогтоол хүчингүй болох гол үндэслэл болж байна.

2. ЭБШХ-ийг ноцтой зөрчсөн дутагдал мөрдөн байцаалтын шатанд гаргасан байгааг анхааралгүй хэргийг эцэслэн шийдвэрлэсэн зөрчил нэг биш удаа гарчээ. Тухайлбал: Эрүүгийн хуулинд байхгүй зүйл хэсгүүдээр ял сонсгож, прокурор яллах дүгнэлт үйлдсэн, шүүх ийм яллах дүгнэлттэй хэргийг авч шийдвэрлэсэн, насанд хүрээгүй яллагдагчид ял өөрчлөн сонсгож удаа дараа байцаахдаа эцэг, эх, сурган хүмүүжүүлэгч, өмгөөлөгчийг оруулаагүй, ЭБШХ-ийн 45 дугаар зүйлд заасан гэрчид гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг нь тайлбарлаж өгөлгүйгээр байцаасан, бие биенийх нь эсрэг мэдүүлэг гаргуулсан, ийм мэдүүлгийг яллах гол баримт болгосон зэрэг шүүгдэгчийн хуулиар хамгаалагдсан эрхийг хязгаарлаж, ЭБШХ-ийг ноцтой зөрчсөн байгааг анхаарч дүгнэлт хийхгүйгээр ял шийтгэл оногдуулжээ. Ийм зөрчлийг Чингэлтэй дүүргийн шүүх Батчулуун, Б.Бат-Эрдэнэ нарт холбогдох 2003 оны 21 дүгээр шийтгэх тогтоолтой хэрэгт гаргасан байна.

3. Шүүхээс гарч буй эрх зүйн баримт бичгүүд /шийтгэх тогтоол, магадлал/ нь ЭБШХ-ийн 294, 295, 296, 297 дугаар зүйлүүдэд заасан шаардлагад нийцэхгүй, үг найруулгын хувьд ойлгомжгүй байна. Тухайлбал: Дорнод аймгийн сум дундын шүүхийн 2002 оны 88 дугаар шийтгэх тогтоолтой Х.Цэрэгбаатар, Н.Сандагдорж нарт холбогдох хэрэг, 2002 оны 77 дугаар шийтгэх тогтоолтой Б.Болормаа, О.Энхжаргал, Б.Туяа нарт холбогдох хэргийг хянасан аймгийн давж заалдах шатны шүүхийн магадлал ойлгомжгүй, шүүхээс гаргаж буй эрх зүйн баримт бичиг “хууль ёсны үндэстэй байх” зарчимд нийцээгүй, ёс төдий хэлбэр агуулсан,

магадлалын найруулга муу, ялангуяа тогтоох хэсгийн заалтууд учир нь ойлгогдохгүй болсон, магадлалын агуулга, заалтыг хэрэгжүүлэх, хэрэглэх ажиллагаанд бэрхшээл учруулж болохуйц байна.

4. Шүүн таслах ажиллагаанд хайнга хариуцлагагүй хандах явдал цөөнгүй гарч байна. Жишээ нь: Баянгол дүүргийн шүүх 2003 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 27-р шийтгэх тогтоолоор шүүгдэгч С.Батхүүд холбогдох хэргийг шийдвэрлэхдээ, түүний эцгийн нэрийг “Жаргал, “Сүхээ” гэж хоёр өөрөөр овоглосон өөр өөр баримт хэрэгт авагдсан байхад Батхүүгийн эцгийн овог Сүхээ, Жаргал нарын хэн болохыг тогтоогоогүй, мөн Говь-Алтай аймгийн сум дундын шүүх 2003 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 07 дугаар шийтгэх тогтоолоор Д.Жаргалсайхан буюу Д.Жаргал гэгчид ял шийтгэл оногдуулахдаа шүүгдэгч хэн гэдэг нэртэй болохыг нь албан баримтаар тогтоож шийдвэрлээгүй байна.

Мөн Дархан–Уул аймгийн давж заалдах шатны шүүх нь давж заалдах хугацаа хэтэрсний дараа давж заалдах гомдол гаргасан иргэний нэхэмжлэгч, түүний өмгөөлөгч нарын гомдлоор сум дундын шүүхийн 2002 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 343 дугаар шийтгэх тогтоолтой Ж.Гүнчин, С.Өлзийтогтох нарт холбогдох хэргийг хянан хэлэлцэж, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож хэргийг нэмэлт мөрдөн байцаалтанд буцаасан нь ЭБШХ-ийн 303 дугаар зүйлийн 303.1-дэх хэсэгт заасан “Ялтан, хохирогч тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч эсэргүүцэл бичих эрхтэй” гэсэн заалт, мөн хуулийн 306 дугаар зүйлийн 306.2-т заасан “Энэ хуулийн 304 дүгээр зүйлд заасан хугацаа хэтрүүлж гаргасан гомдол, эсэргүүцлийг шүүх хүлээн авахгүй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Судалгааг үндэслэн Эрүүгийн хууль, Эрүүгийн Байцаан шийтгэх хуулийг шүүхийн практикт хэрэглэхэд гарч буй алдаа, зөрчлийг арилгах, нэгдсэн ойлголт тогтоох зорилгоор **Зөвлөмжлөх нь:**

1. Улсын Дээд шүүхийн “Эрүүгийн шинэ хуулийг дагаж мөрдөх журмын тухай” 2002 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 264, “Эрүүгийн Байцаан шийтгэх хуулийн зарим зүйл, заалтыг хэрэглэх журмын тухай” 2002 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 275 дугаар тогтоолын заалтуудыг сайтар судалж, нэг мөр ойлгон, шүүн таслах ажиллагаанд баримталж ажиллах.

2. Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлд заасан нөхцлийг хангаагүй этгээдийн ялыг тэнсэж, хянан харгалздаг, хянан харгалзах хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдсэн этгээдийн ялыг дахин тэнсэж хууль буруу хэрэглэж байгаа дутагдлыг таслан зогсоох.

3. Шүүх, шүүгчдээс гаргаж байгаа эрхийн актыг хэл зүйн найрлага болон үг, үсгийн алдаагүй, бичиг хэргийн стандартыг баримтлан бичих, түүнчлэн эрхийн актын хууль ёсны үндэслэлтэй байх зарчмыг мөрдлөг болгох.

4. Эрүүгийн хуулийн 71 дүгээр зүйлд заасан “Хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх” гэдгийг зөвхөн хуульд заасан

- анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн
- гэм буруутай этгээд хохирогчтой сайн дураар эвлэрсэн
- учруулсан хохирлоо бүрэн төлсөн гэсэн 3 шаардлагыг хангасан нөхцөлд шүүгдэгчийг хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болох эсэхийг шийдвэрлэх.

5. Шүүхээс ял шийтгэл болон дэглэмийн асуудлыг шийдвэрлэхдээ хэрэгтний эрх зүйн байдлыг дордуулахгүй байх нөхцлийг анхаарч Эрүүгийн хуулийн 12 дугаар зүйлийн заалтуудыг зөв хэрэглэж хэвших.

6. Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан хэргийг явуулахдаа гомдол гаргах хугацаа хэтэрсэн эсэх, гомдол гаргагч нь эрх бүхий субъект мөн эсэхийг нягтлан шалгаж, гомдлыг талуудад мэдэгдэж тайлбар гаргуулах талаар ЭБШХ-ийн шаардлагыг хангаж ажиллах.

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ
ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ**